



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024.11.06 № 30

Төрийн өмчит компанийн талаар
асуулга тавьж, мэдээлэл авах тухай

Монгол Улс Үндсэн хуульдаа дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлог бүхий олон хэвшил бүхий эдийн засагтай байхаа зарлаж, нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөн, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалахаа тунхагласан билээ. Гэвч зөвхөн сүүлийн 2 жилийн дотор улсын төсөв 50 хувиар өсөж, нийт эдийн засаг дах төсвийн оролцоо 37.7 хувьд хүрч аажим аажмаар эдийн засаг дах төрийн оролцоо нэмэгдсээр байна. Энэ оролцоо нэмэгдэх тусам хувийн хэвшлийн орон зай буурч, зарим салбаруудад төр нь хувийн хэвшилтэйгээ өрсөлдөхүйц нөхцөл байдал үүсэж, төрийн зохицуулалттай бизнесүүд нь ялгаран үлдэх аюул занал бий болж буй нь анхаарууштай асуудал юм. Улсын Их Хурлын гишүүний хувьд өнгөрсөн парламентад төрийн болон орон нутгийн өмчит компанийн тооны дээд хязгаарыг тогтоож өгөхөөр “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” тогтоолын төслийг өргөн барьсан билээ.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн тоо 2023 оны байдлаар 99 байгаа бөгөөд эдгээр хуулийн этгээд 58,087 ажиллагсадтай, 23.6 их наяд төгрөгийн орлоготой, 16.9 их наядын зардалтай, 22.7 их наяд төгрөгийн өр төлбөртэй, нийт 64.2 их наяд төгрөгийн хөрөнгөтэй байгаа нь төрийн өмчит компаниудын тэлэлт, эрх мэдэл, эд хөрөнгийн төвлөрөл үүсэж байгааг харж болохоор байна. 2021 оноос 2023 оны статистик тоон мэдээллийг харахад төрийн өмчит хуулийн этгээдийн тоо 7-оор багассан боловч хуулийн этгээдүүдийн ажилтнуудын тоо 3 жилийн дунджаар 2,400 гаруй ажилтнаар, өр төлбөр 2.3 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Эдгээр 99 компани 2023 онд 4.9 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан гэх боловч “Эрдэнэс Тавантолгой” ХК 3.5 их наяд төгрөг, “Эрдэнэт үйлдвэр” 0.8 их наяд төгрөг, “Эрдэнэс Монгол” ХХК 0.2 их наяд төгрөг, нийт 4.5 их наяд төгрөг буюу 99 компанийн ашгийн 91.8%-ийг 3 компани бүрдүүлсэн байгаа нь харамсалтай.

Монгол Улсын Засгийн газраас хууль тогтоомжийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдүүдэд авч хэрэгжүүлж байгаа үр ашгийг нэмэгдүүлэх, бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлох, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зэрэг ажлууд үр дүнгээ өгөхгүй байгааг харж болохоор байна.

2024000055

Шинэ бүрдсэн хамтарсан засаг нь 14 мега төсөл тэргүүтэй хөгжлийн төслүүдийг санал болгож байгаагийн дийлэнх нь төр оролцох шаардлагагүй, хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалтыг дайчлах боломжтой харагдаж байгаа билээ. Төрийн ийм санаачилга бүр олон төрийн өмчит компани, нэгжүүдийг бий болгож буй бөгөөд нэр бүхий аж ахуйн нэгжүүдээс бусад төрийн өмчит компаниуд нь асар их алдагдалтай ажиллан улсын төсөв, татвар төлөгчдийн нуруун дээр ачааллыг авчирсаар буй нь анхаарахгүй орхиж боломгүй асуудал болсоор байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дах заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд төрийн өмчит компаниудын үйл ажиллагаатай холбоотой дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн өр төлбөрийг хэрхэн бууруулах, хуулийн этгээдийн үйл ажиллагааг сайжруулах талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар;
2. Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж буй этгээдээс томилж буй Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн шалгуур, боловсрол, ажлын туршлага, тэдгээрийн тайлан, үнэлгээ;
3. Төрийн өмчит хуулийн этгээдийн ажилтнуудын тоо болон дундаж цалин, сүүлийн жилүүдийн өөрчлөлтийн талаар;
4. Ирэх 4 жилд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит компаниудын жагсаалт болон түүнд баримтлах шалгуур үзүүлэлтийн талаар;
5. Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр тогтоолуудад нэр дурдагдсан төрийн өмчит компаниудын 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй худалдах ажил бүрэн хэрэгжээгүй шалтгаан, цаашид авах арга хэмжээний талаар;
6. Засгийн газраас баримталж байгаа Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх бодлого болон төр оролцохгүй бизнесийн чиглэл, хувийн хэвшлийн гүйцэтгэх боломжтой ажил үйлчилгээг хэрэгжүүлж буй төрийн өмчит компаниудын мэдээлэл, эдгээрийн талаар цаашид авах арга хэмжээний тухай;
7. Төрийн өмчит компаниудын сүүлийн 5 жилийн дотоод аудит, хөндлөнгийн аудитаар илэрсэн зөрчил, ашиглан, шамшигдуулалт, тэдгээрийн мөрөөр авсан арга хэмжээний талаар болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуульд заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ

2024000055